

Монгол Улсын Засгийн газар COVID-19-ийн халдвар тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эртнээс эрчимтэй авч эхэлсэн. Боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг 1-р сарын 27-ноос эхлэн албан ёсоор зогсоож, коронавирусын халдвар илэрсэн улсууд руу зорчих аялалын хориг тавьсан төдийгүй 2-р сарын 13-нд Монгол улс онцгой байдлын өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэн. Мөн 2020 оны 2-р сарын 24-26-ний өдрүүдэд тохиосон Сар шинийн баярын үеэр коронавирусын халдвар гарах болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Улсын Онцгой Комиссоос хот хоорондын зорчих хөдөлгөөнийг хориглох шийдвэр гаргасан. Нийслэл Улаанбаатар хот хүн амын төвлөрөл ихтэй, Монгол улсын нийт хүн амын тэн хагас нь оршин суудаг. Үүгээр зогсохгүй, Улаанбаатар хотоор дамжин зорчих хөдөлгөөн их тул коронавирусын халдварыг улс даяар тараах эрсдлийн хамгийн том хүчин зүйлсийн нэг болж байна. Эрсдлийн бэлэн байдлыг цаг ямагт хангаж, коронавирус илэрсэн үед авах арга хэмжээг чанаржуулахын тулд, иргэдийн орж, гарах урсгалын талаарх бүртгэл мэдээллийг сайжруулах ажлыг Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар (НЗДТГ), Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ)-ын Монгол дахь салбарын техник туслалцаатайгаар хэрэгжүүлж байна. НЗДТГ болон ОУШХБ-ын хамтын ажиллагааны дагуу мэдээлэл цуглуулах ажилд 300 гаруй эмнэлгийн болон боловсролын салбарын ажилтныг дайчлан хамруулж, ДТМ аргачлалд сурган, хэрэгцээт зөвлөмж, техникийн туслалцаагаар ханган ажиллаж байна. Хот хоорондын хөдөлгөөн хязгаарлалттай үед буюу 2-р сарын 27-ны 08 цагаас 3-р сарын 3-ны 06 цаг хүртэл урсгал хөдөлгөөнийг хянах ажлын түршилтын үе хийгдэж, үүнээс хойш 3-р сарын 24-ний өдрийг хүртэл үргэлжилнэ. Нийслэлийн ойролцоох 6 (Эмээлт, Баруунтуруун, Гүнт, Өлзийт, Морин, Налайх) шалган нэвтрүүлэх товчоод дээр тээврийн хэрэгслийн төрөл, зорчигчдын тоо, хүйс, зорчин явж буй чиглэлийн талаарх мэдээллийг 24 цагийн түрш иргэдээс авч байна. Хэдийгээр ДТМ аргачлалыг нийслэл хотод анх удаа ашиглаж байгаа боловч дэлхийн 80 гаруй улсад онц байдлын үед ашигладаг ба зөвхөн 2018 онд л гэхэд 40 сая гаруй хүнийг хамруулжээ. Мөн 2018 онд Өмнөд Судан улсад Эбола вирус тархах үеэр иргэдийн хөдөлгөөнийг тандах зорилгоор ДТМ аргачлалыг амжилттай хэрэгжүүлсэн байна. Монгол улсын хувьд Онцгой Байдлын Ерөнхий Газар, ОУШХБ хамтран 2018 оноос хойш 21 аймаг, 330 сумд дахь иргэдийн хөдөлгөөнийг баримжаалан тандаж байгалийн гамшиг, тэр дундаа зудын нөхцөл үүссэн үед ажиллах бэлтгэл ажлыг хангах зорилгоор уг аргачлалыг хэрэглэж ирсэн.

ТОЙМ ТОО

419,505

Хөдөлгөөний нэмэгдсэн дүн ДТМ (УХЦ) урсгал хянасан хөдөлгөөний цэгээр хянасан.

7,352 ↑

Сүүлийн 24 цагт бүртгэгдсэн хөдөлгөөн

303,640

Хориг тавигдсанаас хойшхи хугацаанд бүртгэгдсэн хөдөлгөөн (Здугаар сарын 3-9ний өдрүүдэд)

ХҮН АМ ЗҮЙ

XX% - Нийт
XX% - Сүүлийн 24 цагт



ЭРЭГТЭЙ

49%
62%



ЭМЭГТЭЙ

31%
32%



ХҮҮ


11%
3%




ОХИН

19%
3%

ХҮНИЙ ХӨДӨЛГӨӨН (НИЙТ)



ХӨДӨЛГӨӨНИЙ ЧИГЛЭЛ




ТОВЧООД ДЭЭРХ ХӨДӨЛГӨӨНИЙ УРСГАЛ





Товчоо	НИЙТ			2020-3-12		
	НИЙТ	Орсон	Гарсан	НИЙТ	Орсон	Гарсан
Эмээлт	160,779	103,182	57,597	1,287	762	525
Баруунтуруун	122,517	61,675	60,842	1,844	922	922
Налайх	94,668	48,869	45,799	4,668	2,601	2,067
Морин	74,332	37,419	36,913	2,682	1,344	1,338
Өлзийт	62,735	31,883	30,852	2,633	1,480	1,153
Gunt	57,948	30,534	27,414	108	58	50
НИЙТ	572,979	313,562	259,417	13,222	7,167	6,055

Улаанбаатар хотоос гарах болон орох хөдөлгөөн 2-р сарын 23-ны 08 цагаас 3-р сарын 3-ны 06 цаг хүртэл мөн 3-р сарын 10-ны 07 цагаас 3-р сарын 16-ны 07 цаг хүртэл хязгаарлагдсан болохыг анхаарна уу

УЛААНБААТАР РУУ ЧИГЛЭСЭН ХӨДӨЛГӨӨН



Legend



Энэхүү зураглалд ашигласан хил, хязгаар, нэр, нэршил нь албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөнийг илтгэхгүй болно

ХҮН АМ ЗҮЙ

XX% - Нийт

XX% - Сүүлийн 24 цагт



ЭРЭГТЭЙ

48%

62%



ЭМЭГТЭЙ

32%

32%



ХҮҮ

11%

3%



ОХИН

9%


3%

Улаанбаатарт очсон дүүрэг	Улаанбаатарт очсон										
	?	Багахангай	Багануур	Баянгол	Баянзүрх	Чингэлтэй	Хан-Уул	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	НИЙТ
Улаанбаатар	383	955	4,394	9,801	16,371	6,090	39,156	6,044	52,984	5,812	141,990
Архангай	26	3	20	1,962	2,668	825	1,151	53	3,545	728	10,981
Баянхонгор	-	-	-	24	32	16	13	5	272	9	371
Баян-Өлгий	4	-	-	46	94	20	21	6	122	43	356
Булган	45	18	19	1,592	2,028	590	1,082	41	2,230	533	8,178
Дархан-Уул	28	13	44	2,228	2,865	816	1,541	130	4,127	913	12,705
Дорнод	1	3	-	309	1,287	235	253	-	379	287	2,754
Дорноговь	14	6	3	609	1,431	171	333	13	452	314	3,346
Дундговь	21	-	-	760	1,493	316	974	-	1,052	392	5,008
Говь-Алтай	4	4	19	307	600	135	207	3	632	155	2,066
Говьсүмбэр	14	3	12	487	1,480	170	310	2	313	319	3,110
Хэнтий	3	3	11	726	3,726	434	501	4	614	661	6,683
Ховд	-	-	-	32	30	21	24	-	243	2	352
Хөвсгөл	16	12	43	1,195	1,510	398	672	28	1,724	471	6,069
Орхон	28	-	12	1,495	2,132	495	1,218	67	2,266	729	8,442
Сэлэнгэ	60	7	63	3,022	3,422	1,109	1,601	128	3,623	1,146	14,181
Сүхбаатар	2	-	11	268	1,340	103	160	15	201	176	2,276
Төв	160	56	163	8,657	11,486	4,190	8,355	250	16,815	4,009	54,141
Өмнөговь	14	1	16	681	1,071	196	1,041	14	1,069	238	4,341
Өвөрхангай	57	5	48	2,116	2,633	844	1,805	85	3,966	680	12,239
Завхан	17	-	4	667	1,095	235	498	9	815	277	3,617
?	13	3	-	96	275	29	74	34	150	90	764
НИЙТ	910	1,092	4,882	37,080	59,069	17,438	60,990	6,931	97,594	17,984	303,970

Улаанбаатар хотоос гарах болон орох хөдөлгөөн 2-р сарын 23-ны 08 цагаас 3-р сарын 3-ны 06 цаг хүртэл мөн 3-р сарын 10-ны 07 цагаас 3-р сарын 16-ны 07 цаг хүртэл хязгаарлагдсан болохыг анхаарна уу



УЛААНБААТАРААС ГАРСАН ХӨДӨЛГӨӨН



Энэхүү зураглалд ашигласан хил, хязгаар, нэр, нэршил нь албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөнийг илтгэхгүй болно

ХҮН АМ ЗҮЙ

XX% - Нийт

XX% - Сүүлийн 24 цагт



ЭРЭГТЭЙ

50%

51%



ЭМЭГТЭЙ

29%

35%



ХҮҮ

11%

7%



ОХИН

10%

7%

Улаанбаатараас гарсан дүүрэг	?	Багахангай	Баянзүрх	Багануур	Баянгол	Чингэлтэй	Хан-Уул	Налайх	Сонгинохайрхан	Сүхбаатар	НИЙТ
Арханагай	83	-	789	5	585	346	364	25	1,737	224	4,158
Баянхонгор	55	-	310	41	286	100	232	5	685	103	1,817
Баян-Өлгий	-	-	87	-	56	-	12	-	48	21	224
Булган	73	-	850	13	592	268	436	16	1,254	194	3,696
Дархан-Уул	30	-	1,734	35	1,320	504	904	106	3,062	565	8,260
Дорнод	5	-	1,148	-	224	168	260	4	280	200	2,289
Дорноговь	30	-	1,853	10	717	301	420	-	452	314	4,097
Дундговь	7	-	1,094	5	421	209	673	19	776	268	3,472
Говь-Алтай	17	5	110	13	67	47	75	6	236	65	641
Говьсүмбэр	8	-	1,295	13	331	148	204	-	283	195	2,477
Хэнтий	7	4	3,014	6	594	324	387	-	436	404	5,176
Ховд	5	-	142	-	56	25	101	23	174	36	562
Хөвсгөл	12	-	385	3	281	100	223	-	610	137	1,751
Орхон	27	6	1,356	36	938	404	805	54	2,255	432	6,313
Сэлэнгэ	13	3	2,326	76	2,040	647	1,228	179	3,113	690	10,315
Сүхбаатар	3	-	929	2	108	82	156	-	129	175	1,584
Төв	281	40	9,702	130	6,914	3,479	7,640	213	14,923	3,267	46,589
Өмнөговь	14	6	1,383	28	705	326	1,180	20	1,401	419	5,482
Увс	15	-	95	-	35	34	55	21	196	37	488
Өвөрхангай	79	-	1,031	14	697	283	582	18	1,601	327	4,632
Завхан	17	-	234	7	100	43	127	4	415	63	1,010
?	24	-	72	6	54	38	46	18	222	22	502
НИЙТ	805	64	29,939	443	17,121	7,876	16,110	731	34,288	8,158	115,535

Улаанбаатар хотоос гарах болон орох хөдөлгөөн 2-р сарын 23-ны 08 цагаас 3-р сарын 3-ны 06 цаг хүртэл мөн 3-р сарын 10-ны 07 цагаас 3-р сарын 16-ны 07 цаг хүртэл хязгаарлагдсан болохыг анхаарна уу